



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2023 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

Ард түмний олонхийн засаглал
намын хаягийн өөрчлөлтийг
бүртгүүлэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, С.Батдэлгэр, М.Батсуурь, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, Н.Баярмаа, П.Золзаяа, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Ард түмний олонхийн засаглал намын даргаас “хаягийн болон цахим шуудангийн хаягийн өөрчлөлтийг бүртгүүлэх” тухай өргөдлийг шүүгч П.Соёл-Эрдэнийн илтгэснээр, хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Ард түмний олонхийн засаглал намын дарга А.Батдоржоос “... Улсын дээд шүүхийн цахим хуудас дахь Улс төрийн намын бүртгэлийн цахим санд буй Ард түмний олонхийн засаглал намын хаягийн бүртгэл дэх Чингэлтэй дүүргийн 1-р хороо, Центр 34, В корпус 508 тоот түрээсийн байрыг 2021 онд Ковид цар тахлын үед гэрээгээ цуцлан эзэмшигчдэд нь шилжүүлсэн.

2023 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Монгол улс, Улаанбаатар хот, “Чингэлтэй дүүргийн 2-р хороо, С.Чоймболын гудамж, Монголын Үйлдвэрчний Эвлэлийн холбоо /МҮЭХ/-ны харьяа Үйлдвэрлэл үйлчилгээний төвийн 208 тоот” оффисын зориулалттай өрөөг түрээсийн гэрээ хийж эзэмших болсон тул хаягийн өөрчлөлтийг бүртгэнэ үү.

Түүнчлэн Улсын дээд шүүхийн улс төрийн намын бүртгэлийн цахим сан дахь тус намын цахим шуудангийн хаяг нь “atoznam@gmail.com” гэж бүртгэгдсэн байгаа боловч, энэ бүртгэлд “19” гэх тоо дутуу орхигдсон байх тул “atoznam19@gmail.com” гэж залруулан бичилт хийж өгнө үү” гэх хүсэлтийг гаргаж, 10 хуудас баримт ирүүлжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Ард түмний олонхийн засаглал намын хаягийн өөрчлөлтийг тус намын мэдээлэлд бүртгэж шийдвэрлэв.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Хуулийн этгээдийн хувийн хэрэгт дараах мэдээллийг агуулна” гээд, 10.1.3-т “хуулийн этгээдийн ерөнхий захиргаа оршин байгаа газрын албан ёсны хаяг ...” гэж, Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.5-д “намын гүйцэтгэх байгууллага байнга оршин байгаа хууль ёсны хаяг” гэж тус тус зааснаар намын

гүйцэтгэх удирдлагын байнга оршин суугаа хаяг, түүний өөрчлөлт нь улс төрийн намын улсын бүртгэл, хувийн хэргийн агуулгад заавал тусгах мэдээлэлд хамаарч байна.

Ард түмний олонхийн засаглал нам нь Чингэлтэй дүүргийн 1-р хороо, Центр 34В, 508 тоот өрөөг түрээсэлж үйл ажиллагаа явуулж байсан боловч тус намын хаяг өөрчлөгдөж, цаашид Үйлдвэрчний эвлэлийн холбооны, Үйлдвэр үйлчилгээний төвийн 208 тоот өрөөнд үйл ажиллагаа явуулах болсон байх тул хаягийн өөрчлөлтийг бүртгэх үндэслэлтэй.

Улс төрийн намын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Намын дүрэм, мөрийн хөтөлбөр, тэдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хууль, энэ хуультай нийцэж байгаа эсэхэд Улсын дээд шүүх хяналт тавина ...” гэж заасан, намыг төлөөлөх эрхтэй этгээд буюу намын дарга шүүхэд хүсэлт гаргасан, нам өөрийн албан ёсны хаягийг өөрчлөн тогтоох бүрэн эрхтэй тул бүртгэхээс татгалзах үндэслэл байхгүй байна.

Мөн цахим шуудангийн хаягийг зөвтгөж бүртгүүлэх хүсэлтийг хамтад нь нэгтгэн шийдвэрлэх бүрэн боломжтой.

Иймд, Ард түмний олонхийн засаглал намын дарга А.Батдоржоос ирүүлсэн “Ард түмний олонхийн засаглал намын хаягийн болон цахим шуудангийн хаягийн өөрчлөлтийг бүртгүүлэх” хүсэлтийг хангах нь зүйтэй гэж Нийт шүүгчийн хуралдаанаас үзэв.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон

ТОГТООХ НЬ:

1.Улсын төрийн намын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасныг баримтлан Ард түмний олонхийн засаглал намын хаягийг “Чингэлтэй дүүргийн 2-р хороо, С.Чоймболын гудамж, Монголын Үйлдвэрчний Эвлэлийн холбоо /МҮЭХ/-ны харъяа Үйлдвэрлэл үйлчилгээний төвийн 208 тоот” гэж, цахим шуудангийн хаягийг “atoznam19@gmail.com” гэж тус тус намын улсын бүртгэлийн мэдээлэлд өөрчлөн бүртгэсүгэй.

2.Өргөдөл гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 150,000 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

П.СОЁЛ-ЭРДЭНЭ